

ОЛОН УЛСЫН АМЬДРАЛ 2001 ОНД**Д.Золбоо***

2001 он хүн төрөлхтний түүхэнд олон чухал үйл явдлаар баялаг он жилүүдийн нэг байлаа. Өнгөрсөн хугацааг дүгнэн бичиж, үнэлэлт дүгнэлт өгөх нь судлаач бидний нэг зорилго билээ. Жил бүрийн эцэст манай өдөр тутмын хэвлэлүүдэд дэлхийн болон Монголын хэмжээн дэх хамгийн онцлох үйл явдлын талаар багагүй зүйл нийтлэгдэж байгаа билээ. Хэдийгээр сэтгүүлчдийн эдгээр нийтлэлд олон нийтийн санаа бодлыг тусгасан хэдий боловч албан ёсны, судалгаа шинжилгээний байгууллагын өгөх дүгнэлт дутмаг байж болох талтай. Цаашдаа манай хүрээлэн ч гэсэн эрдэм шинжилгээ судалгааны үүднээс дэлхийн хэмжээний онцлох буюу хамгийн дуулиан шуугиантай үйл явдал болон Монголын түүхэнд холбогдох хамгийн чухал үйл явдал, хувь хүнийг нэрлэн зарладаг болох бизээ. Ер нь аль нэгэн улс гүрэн ямар асуудалд ач холбогдол өгч, анхаарал тавьж байна, хоорондоо юугаараа ялгаатай, юугаараа ижил төстэй байна вэ гэдгийг судлана гэдэг бол судалгааны бас нэгэн сонирхолтой сэдэв байж болох юм.

9-р сарын 11-нд АНУ-д болсон гэмт халдлага, түүнийг тойрсон эдийн засгийн хямрал, алан хядах үйл ажиллагааны эсрэг чиглэсэн Афганистанд өгсөн хариу цохилт, олон улсын хамтын ажиллагаа зэргийг өнгөрсөн жилийн дэлхийн түүхэнд бичигдэх гол үйл явдал гэдэг дээр дотоод, гадаадын хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийн санал нэгдэж байна.

Манай өдөр тутмын томоохон хэвлэлийн нэг “Зууны мэдээ” сонины 2001 оны 12-р сарын 28-ны № 311-д “2001 онд дэлхийг донсолгосон үйл явдын товчоон” нэртэйгээр 10 үйл явдлыг нэрлэсэн байна. Үүнд:

1. Японы Ерөнхий сайд Ё.Мори огцорч, Ж.Коизүми сонгогдсон,

2. Югославын Ерөнхийлөгч асан С.Милошевичийг олон улсын цэргийн шүүхэд шилжүүлсэн,

* Д.Золбоо - Олон улс судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан

3. АНУ пуужингийн довтолгооноос хамгаалах гэрээнээс гарсан,
4. АНУ-д болсон аймшигт алан хядлага,
5. Бээжин хот 2008 оны зуны олимпыг зохион явуулах эрх авсан,
6. Оросын цэргийн цөмийн “Курск” шумбагч хөлөг онгоцыг далайн гүнээс татаж гаргасан,
7. Хайнань арал дахь АНУ-Хятадын сөргөлдөөн,
8. Оросын сансарын “Мир” станцыг далайд живүүлсэн,
9. Малын халдварт шүлхий өвчин Европыг догсолгосон,
10. Балбын хунтайж гэр бүлээ хөнөөсөн зэргийг нэрлэсэн байна. Бусад хэвлэлүүдийн нэрлэсэн үйл явдлуудад нь зарим нэг өөр зүйл байх боловч ерөнхийдөө адилхан байна.

Дэлхий дахинд алдартай TIME сэтгүүлийн 2001 оны 12-р сарын 24-ний 25 дугаарт нийтлэгдсэн “2001 оны хамгийн сайн, хамгийн муу” гарчигтай нийтлэл гарчээ. Уг сэтгүүлийн газраас дэлхий дахинд болсон гол гол үйл явдлыг хүмүүс, бизнес, шуугиан, хөгжим, ном, кино, спорт, дизайн, гэрэл зураг гэсэн сэдвийн дор нэлээд өргөн сэдвийг хамарч ангилан төрөлжүүлжээ.

Гэхдээ эдгээр нэрлэсэн үйл явдлуудын ихэнх нь өрнийн улс орнууд тэр дундаа АНУ-ын түүхэнд холбоотой зүйлсийг голлон нэрлэсэн байгааг харж болох юм. Тухайлбал, эдийн засгийн салбарт гарсан хамгийн эерэг үйл явц нь 9-р сарын 11-ний үйл явдлын дараа болсон эдийн засгийн хямралыг жилийн эцэс гэхэд давж гарсныг нэрлэж байгаа бол, хамгийн сөрөг үйл явдалд АНУ-ын томоохон компаниудын нэг Энроний дампуурал, Хятадад болсон уурхайн дэлбэрэлтээр 5000 хүний амь нас сүйдсэн үйлдвэрлэлийн осол, Аргентиний эдийн засгийн хямрал, Индонезид дэх газрын тосны төлөөх зөрчилдөөн, хамгийн шуугиантай үйл явдалд АНУ-ын цэргийн шумбагч хөлөг онгоц Японы сургалтын завийг мөргөн живүүлсэн хэрэг зэргийг нэрлэсэн байна.

Энэ удаад уг сэтгүүлд нийтлэгдсэн энэхүү өгүүллийн хамгийн сонирхолтой нь байж болох өнгөрсөн жилийн онцлох хүмүүсийн талаарх материалыг сонирхуулья.

2001 оны хүмүүс.

Руди Жюлиани (Rudy Giuliani). Нью-Йорк хотын эмх цэгц, дотоод асуудлаа шийдэхийн төлөө ажиллаж байсан түүнд 2001 оны 9-р сарын 11-ний өдөр Америкийн ямар ч хотын даргад

урьд өмнө нь тулгарч байгаагүй гай гамшиг учирснаар бэрхшээлээс гарахын төлөө тэрбээр бүх хүч чадлаа энэхүү зовлонг гэтлэн давахад зориулан ажиллах болжээ. Үнэн хэрэгтээ маш их ядарч туйлдсан боловч хэзээ ч шантарч, няцаагүйгээр барахгүй айж сандарсан хотын иргэд төдийгүй нийт ард түмэндээ өөрийн биеэр үлгэрлэн дагуулж эр зориг, даруу төлөвийн бэлгэ тэмдэг болж байв. Тэгээд ч уг сэтгүүлийн дараагийн дугаарт Харин 2001 оны гол хүнээр Нью Йорк хотын захирагч Руди Жюлианийг нэрлэсэн байна.

Коси Жонсон (Nkosi Johnson). Өмнөд Африкийн Ерөнхийлөгч Табо Мбеки, төрсөн эхээсээ ДОХ-ын халдвар авсан 12 настай хүү шиг ижил өвчтэй олон сая нутаг нэгтний нэгэн адил хүмүүсийг аюулт өвчнөөс аврахад туслахыг дэлхий нийтэд уриаллаа. Жонсон хүү эхээсээ өнчрөн үлдсэн бөгөөд төрсөн эцгээ ээжийнхээ оршуулга дээр анх олж харан, танилцжээ. Тэрээр “биднийг хүлээн зөвшөөрч, туслан дэмжээч, хэрэв үүнээс татгалзвал Африкийн ирээдүй аюулд учирах болно” гэж ямар ч албаны хүнээс илүүгээр ДОХ-ын аюулыг олон нийтэд ойлгуулж өгснөөрөө эр зоригийн бэлгэ тэмдэг болон үлдсэн боловч харамсалтай нь 6-р сарын 1-нд насан өөд болжээ.

Хатан хаан Митти-марит Тжессем Хойби (Mette-Marit Tjessem Noiby). Наймдугаар сард Осло хотын Катэдрал шилтгээнд 4 хаан, 5 хатан хаан, 10 хунтайж болон 12 гүнж цуглан Норвегийн үе залгамжлах хунтайж Хааконьг Митти-марит гэгч дагавар хүүхэдтэй бүсгүйтэй гэрлэх ёслолын ажиллагаанд оролцжээ. Шинээр төрсөн хүүхдийн талаас илүү хувь нь эцэг эхээ гэрлэхээс өмнө төрдөг энэ оронд энэхүү шаргал үст үзэсгэлэнт бүсгүй жинхэнэ ард олны дундаас төрсөн жирийн нэгэн юм. Уламжлалаа баримтлагчдын зүгээс олон тооны эсэргүүцэл, тэмцэлтэй тулгарсан ч хайр дурлалдаа хөтлөгдөн санасандаа хүрсэн хаан хүү Хаакон харин дээд зиндааныхны дундах хамгийн дээд зиндааны хойд эцэг болсон юм.

Жуничиро Койзуми (Junichiro Koizumi). Японы Засгийн газрын шинэ тэргүүн болсон түүнийг өөрчлөлтөд аргаа барж цөхөрсөн олон нийт эрс шийдвэртэйгээр өргөн гаргаж ирсэн юм. Тэрбээр идээлэн буглаж буй эдийн засгийн асуудал болон шинэтгэлүүдээс үл шалтгаалан амжилтанд хүрэхийг амлан ажиллаж байна.

Ж.К.Роулин (J.K. Rowling). Энэ зохиолч бүсгүйн зохиолын гол баатар жаал хүү Харри Поттер түүнийг дэлхийн хамгийн баян зохиолчийн нэг болгох замыг нээж өгсөн юм. Англи хэлээр бичдэг зохиолчдын бүтээл тэр бүр амжилт олж чадахгүй байхад “Харри-гийн Гэрэл 2000”-ийн цуврал дэлхий даяар 100 саяаас илүү хувиар борлогдож бусад хэвлэлийг номын шүүгээн дээрээс шахан түрж байна. Америкийн алдарт Уорнэр Брозерс компани энэхүү зохиолоор сэдэвлэсэн кино хийсэн нь ч өнгөрсөн оны хамгийн ашиг орлоготой киноны нэг болж чалсан байна.

Гүнж Айко (Aiko). Түүний дипломат мэргэжилтэй ээжийг үе залгамжлах хан хүү Нарухито-той 1993 онд гэрлэх үед Япон залуу бүсгүйчүүд гүнж Масаког хааны гэр бүлийн хүн болсныг арга буюу хүлээн зөвшөөрлөгөөсөн юм. Дээд зиндааны гэр бүлийн тогтсон зан заншлын дагуу Харвардын Их сургууль төгссөн бүсгүй олон нийтийн хараанаас нэг хэсэг далд байсан юм. Одоо бол орчин үеийн хийштэй өлгийнний бүтээлэг, 12-р сарын 1-нд төрсөн бяцхан гүнж Айкогийн өмнүүр унжаастай бий. Одоогоор хаан ширээ залгамжлах нуган үр төрөөгүй байгаа учраас японы олон нийтийн дунд эмэгтэй хүн угсаа залгамжилж болох эсэх талаар толгой эргэм их хэлэлцүүлэг үндэсний хэмжээнд явагдаж байна. Хамгийн сонин нь япончуудын 86 хувь нь “хатан хаан Айко” гэх нь ихэд сонсголонтой байна гэсэн санал бодолтой байгаа юм.

Гао Жан (Gao Zhan). Вашингтон хотын Америкийн Их сургуулийн судлаач хятад гаралтай багш бүсгүйг Хятадад буцаж ирэхэд түүнийг АНУ-ын тагнуулч гэж үзэн баривчлан хорьсон бөгөөд одоогоос 6 сарын өмнө Хятадаас хөөн гаргасан юм. Нөхөр, төрсөн хүү нь Америкийн харьяат энэ бүсгүй Хятадын зүгээс ирэх заналхийллийг үл ойшоохыг уриалахын зэрэгцээ өөрийнхөө туршлагын талаар нээлттэй ярьж яваагаараа онцлог юм. Энэхүү хурц асуудал болоод байгаа социологчийн судалгааны сэдэв нь жирийн нэгэн хүйс судлал судалгааны ажил байсан байна.

Деннис Тито (Dennis Tito). Оросууд түүнийг 20 сая долларынх нь хариуд сансрын тойрог замд гаргаснаар Америкийн тэрбумтан энэ хүн дэлхийн анхны сансрын жуулчин болсон юм. Олон улсын сансрын буудалд 60 настай хүн байрлахад тийм ч таатай бус байна гэж Үндэсний сансар судлалын холбоо (NASA) үзэж байсан

юм. Титогийн аялал сансарт аялах олон улсын аялагчдын замыг засч өглөө. Одоогийн байдлаар дараагийн аялагчаар Өмнөд Африкийн Марк Шаттлуорф 25 сая доллараар аялахаар болсон байна. Энэ бүхэн цаашдаа NASA өөрийн үйл ажиллагаандаа өөрчлөлт оруулах хандлага буй болголоо.

Темба Цэри (Temba Tsheri). Өнгөрсөн жил 15 настай Цэри гэдэг хүүг дэлхийн хамгийн өндөр цэг болох Хималайн нурууны Эверест уулын оргилоос 50 метрийн зайд байхад цаг агаарын байдал ихэд хүндэрч, анхааралгүйгээс гаргасан бяцхан алдаанаас болж 5 хуруугаа хайруулж байсан байна. 5-р сарын 23-нд, ихэнх хүүхдүүд өөрсдийнхөө компьютер тоглоомоороо тоглож байдаг энэ насан дээр Цэри хүү дэлхийн зулай Эверестэд гарсан хамгийн залуу хүн болсон юм. Амжилтаа ахиулахын төлөө ажиллаж буй энэ Балба залуу “Би өөрийнхөө судалгааг баяжуулж байна” гэж ярьсан байна.

Стефи Граф ба Эндри Агасси (Steffi Graf and Andre Agassi). Удаан хугацааны турш газрын теннисний од болж байсан энэ 2 хос өөрийн хүү Жадэн Гилийг төрөхөөс 4 хоногийн өмнө 10-р сард гэрлэжээ. Дэлхийн аварга асан бүсгүйн үзэж буйгаар, генийн удамшлын үүднээс харвал хүүгийн эцэг Агассигийн одоогын тоглолтууд нь “Вимблэдон 2021” тэмцээний эхлэл, оршил хэсэг байж болох юм гэж үзэж байна.

TIME сэтгүүлийн нэрлэсэн хүмүүсийн 3 нь Америкийнх, 4 нь Азийнх, 2 нь Европынх, 1 нь Африк тивийнх байгаагаас харахад нэг талыг хэт барилгүй нэлээд бодитой дүгнэсэн гэж үзэж болохоор байна.